



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/170

Мандалговь

Хуулийн хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль явагдаж байгаатай холбогдуулан 2020 оны 6 дугаар сарын 23, 24, 25-ны өдрүүдэд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллуулахыг хориглосугай.

Хоёр. Захирамжийг хэрэгжүүлж тухайн өдрүүдэд аймгийн нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ эрхлэх болон бусад хориглосон үйл ажиллагааг явуулахгүй байхыг иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, удирдлагуудад даалгасугай.

Гурав. Сонгуулийн санал хураалтын үеэр иргэд, олон нийтийн хэв журмыг сахиулж, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, иргэд сонгогчдын аюулгүй байдлыг хангаж, захирамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010471